



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/522

Хэрлэн сум

Сумдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны 10 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Сэтгэл зүйчгүй сумдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх” ажлыг зохион байгуулахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Х.Уртнасан)-т даалгасугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний Хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ